



МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБООНЫ ШАГНАЛЫН ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Монголын банк бус санхүүгийн байгууллагын холбоо /цаашид **“Холбоо”** гэх/-ны гишүүн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, тэдгээрийн зорилго, зорилтыг олон нийтэд таниулан сурталчлах, Холбооны гишүүн шилдэг байгууллага, ажилтныг сонгон шалгаруулж, Холбооны болон бусад байгууллага, торийн шагналд тодорхойлох, шагнаж урамшуулахтай холбогдон үүсэх харилцааг энэ журам /цаашид **“Журам”** гэх/-аар зохицуулна.
- 1.2 Банк бус санхүүгийн байгууллагын салбарын байгууллага, түүний ажилтны эрхэлсэн ажлын ололт амжилт, үр бүтээлийг гол шалгуур үзүүлэлт болгохын зэрэгцээ өндөр ёс зүйтэй байж салбарын хөгжилд оруулсан бодит хувь нэмэр тухайлбал харилцагчийг хамгаалах, тогтвортой санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, комплейнсыг хэрэгжүүлэх чиглэлээр онцгой амжилт гарган ач холбогдол бүхий үүрэг биелүүлсэн байдал мөн Холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцон дэмжсэн байдлыг юуны өмнө харгалзан үзэх зарчмыг баримтална.
- 1.3 Холбооны гишүүн байгууллага, түүний ажилтан, албан хаагчийг шагналд тодорхойлох, сонгон шалгаруулах, шагнаж урамшуулах асуудлыг Холбооны Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх ба нэр дэвшигчдийг шалгуур үзүүлэлтээр дүгнэсэн онооны нийлбэр болон Удирдах зөвлөлийн үнэлгээгээр үнэлж шалгаруулна.
- 1.4 Гишүүн байгууллага нь тухайн жилд Банк бус санхүүгийн байгууллагын шагналын 2-оос дээшгүй төрөлд нэрээ дэвшүүлж болох бөгөөд шаардлага хангасан 1 төрөлд шилдгээр шалгарах боломжтой.
- 1.5 Холбооны тэгш ойн жилд банк бус санхүүгийн байгууллагуудын шилдэг ажилтнуудын шагнал болох “Банк бус санхүүгийн тэргүүний ажилтан”, “Хүндэт жуух” шагналыг Удирдах зөвлөлийн шийдвэрээр журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас нэмж олгож болно.

Хоёр. Шагналын төрөл, шалгуур нөхцөл

- 2.1. Банк бус санхүүгийн байгууллагын шилдэг ажилтны шагнал нь дараах төрөлтэй байна.
- 2.1.1 **Холбооны “Банк бус санхүүгийн тэргүүний ажилтан тэмдэг”:**
 - Банк бус санхүүгийн салбарт 5-аас доошгүй жил, тухайн байгууллагад 3-аас доошгүй жил тогтвор суурьшилтай, идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж буй ажилтныг “Банк бус санхүүгийн тэргүүний ажилтан” тэмдгээр шагнана.
 - Монгол банк, Сангийн яам, Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яам, Санхүүгийн зохицуулах хорооны “Жуух бичиг” болон Холбооны “Хүндэт жуух”-ын аль нэгээр шагнуулж байсан ажилтанг “Банк бус санхүүгийн тэргүүний ажилтан” тэмдгээр шагнана.

- Дээр дурдсан шагналаар шагнагдсанаас хойш 2-оос доошгүй жил үр бүтээлтэй ажилласан ажилтны тодорхойлолтыг үндэслэн Банк бус санхүүгийн тэргүүний ажилтан тэмдгээр шагнаж болно.
- Холбооны “Банк бус санхүүгийн тэргүүний ажилтан” тэмдгээр баяр ёслолын арга хэмжээнд нэг удаа 15-аас /арван тав/ дээшгүй тоогоор шагнаан урамшуулна.
- Гишүүн байгууллагуудын түүхт тэгш ой /5, 10, 15, 20.../-н өдрүүдийг тохиолдуулан 5-аас дээшгүй тоогоор шагнаан урамшуулна.

2.1.2 Холбооны “Хүндэт жуух”:

- Банк бус санхүүгийн салбарт 3-аас доошгүй жил, тухайн байгууллагад 2-оос доошгүй жил тогтвор суурьшилтай, идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж буй ажилтныг “Хүндэт жуух”-аар шагнаан урамшуулна.
- Холбооны “Хүндэт жуух”-ыг баяр ёслолын арга хэмжээнд нэг удаа 20-оос /хорь/ дээшгүй тоогоор шагнаан урамшуулна.
- Гишүүн байгууллагуудын түүхт тэгш ой /5, 10, 15, 20.../-н өдрүүдийг тохиолдуулан 5-аас дээшгүй тоогоор шагнаан урамшуулна.

2.1.3 Дээрх шагналуудыг дагалдах мөнгөн шагналын хэмжээ:

- “Банк бус санхүүгийн тэргүүний ажилтан” тэмдгийг дагалдах мөнгөн шагнал нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байна.
- “Хүндэт жуух” тэмдгийг дагалдах мөнгөн шагнал нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50%-аас доошгүй байна.
- Холбооны шагналын дагалдах мөнгөн шагналыг тухайн ажилтныг шагнуулахаар тодорхойлсон байгууллага нь өөрийн хөрөнгөөс гаргана.

2.1.4 Алтан-Од: Оны шилдэг Гүйцэтгэх захирал, Захирал- 1 хүн

- Тухайн байгууллагын гишүүнчлэлийн хугацаа 3-аас дээш жил байх.
- Гүйцэтгэх захирал нь тухайн байгууллагад 2-оос доошгүй жил ажилласан байх.
- Мэргэжлийн ёс зүйг эрхэмлэгч байх.
- Салбарыг сурталчлан таниулах чиглэлээр бодитой ажил хэрэгжүүлсэн байх.
- Тогтвортой санхүүжилтийн тогтолцоог дэмжигч байх.
- Татвар, нийгмийн даатгалын өргүй байх /байгууллага/
- Активын өсөлт- /Хувьчилсан үзүүлэлт/
- Зээлийн багцын чанар- /Хувьчилсан үзүүлэлт/
- Санхүүгийн зохицуулах хорооны Зохистой харьцааны шалгуурыг тухай жилдээ хангаж зөрчилгүй ажилласан байдал /байгууллага/
- Байгууллагын үйл ажиллагаанд шинэ үйлчилгээ, техник технологийн дэвшлийг нэвтрүүлсэн байдал- /Тоон үзүүлэлт/
- Ажлын байрны өсөлт-/Хувьчилсан үзүүлэлт/
- Холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, дэмжлэг үзүүлсэн байдал

2.1.5 Алтан-Од: Оны шилдэг Газар, Хэлтсийн захирал-2 хүртэлх хүн

- Тухайн байгууллагын гишүүнчлэлийн хугацаа 2-оос дээш жил байх.
- Газар, Хэлтсийн захирал нь тухайн байгууллагад 2-оос доошгүй жил ажилласан байх.
- Мэргэжлийн ёс зүйг эрхэмлэгч байх.
- Тогтвортой санхүүжилтийн тогтолцоог дэмжигч байх.
- Салбарыг сурталчлан таниулах чиглэлээр бодитой ажил хэрэгжүүлсэн байх.
- Татвар, нийгмийн даатгалын өргүй байх /байгууллага/

- Санхүүгийн зохицуулах хорооны Зохистой харьцааны шалгуурыг тухай жилдээ хангаж зөрчилгүй ажилласан байдал /байгууллага/
- Хариуцсан чиглэлээр шинэ үйлчилгээ, техник технологийн дэвшлийг нэвтрүүлсэн байдал- /Тоон үзүүлэлт/
- Холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, дэмжлэг үзүүлсэн байдал
- 2.1.6 Алтан-Од: Оны шилдэг Салбарын захирал-3 хүртэлх хүн**
 - Тухайн байгууллагын гишүүнчлэлийн хугацаа 2-оос дээш жил байх.
 - Салбарын захирал нь тухайн байгууллагад 2-оос доошгүй жил ажилласан байх.
 - Мэргэжлийн ёс зүйг эрхэмлэгч байх.
 - Тогтвортой санхүүжилтийн тогтолцоог дэмжигч байх.
 - ББСБ-ын салбарыг сурталчлан таниулах чиглэлээр бодитой ажил хэрэгжүүлсэн байх.
 - Татвар, нийгмийн даатгалын өргүй байх /байгууллага/
 - Санхүүгийн зохицуулах хорооны Зохистой харьцааны шалгуурыг тухай жилдээ хангаж зөрчилгүй ажилласан байдал /байгууллага/
 - Голлох санхүүгийн үйл ажиллагааг үргэлжлүүлсэн байдал /Хувьчилсан үзүүлэлт/
 - Үйлчилгээний чанарыг дээшлүүлсэн байдал
 - Холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, дэмжлэг үзүүлсэн байдал
- 2.1.7 Алтан-Од: Оны шилдэг Менежер-3 хүртэлх хүн / Мэргэжлийн чиглэлээр ажиллаж буй Ахлах түвшний ажилтнууд /**
 - Тухайн байгууллагын гишүүнчлэлийн хугацаа 2-оос дээш жил байх.
 - Тухайн байгууллагад 2-оос доошгүй жил ажилласан байх.
 - Тухайн жилд мэргэжлийн ёс зүйн алдаа дутагдалгүй ажилласан байх.
 - Татвар, нийгмийн даатгалын өргүй байх /байгууллага/
 - Санхүүгийн зохицуулах хорооны Зохистой харьцааны шалгуурыг тухай жилдээ хангаж зөрчилгүй ажилласан байдал /байгууллага/
 - Хариуцсан ажил /төсөл/-ын гүйцэтгэл /Хувьчилсан үзүүлэлт/
 - Шинээр гаргасан санал санаачилга, түүний бодит хэрэгжилт /Тоон үзүүлэлт/
 - Сургалт, хөтөлбөрт хамрагдсан байдал /Тоон үзүүлэлт/
 - Холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон байдал
- 2.1.8 Алтан-Од: Оны шилдэг мэргэжилтэн-10 хүртэлх хүн /Мэргэжлийн чиглэлээр ажиллаж буй ажилтнууд- Нягтлан бодогч, IT, Хүний нөөц, Харилцагчийн үйлчилгээний ажилтан, Комплаенсын ажилтан, Эдийн засагч, Эрсдэлийн ажилтан, Төслийн ажилтан**
 - Тухайн байгууллагын гишүүнчлэлийн хугацаа 2-оос дээш жил байх.
 - Тухайн байгууллагад 2-оос доошгүй жил ажилласан байх.
 - Тухайн жилд мэргэжлийн ёс зүйн алдаа дутагдалгүй ажилласан байх.
 - Татвар, нийгмийн даатгалын өргүй байх /байгууллага/
 - Санхүүгийн зохицуулах хорооны Зохистой харьцааны шалгуурыг тухай жилдээ хангаж зөрчилгүй ажилласан байдал /байгууллага/
 - Хариуцсан ажил /төсөл/-ын гүйцэтгэл /Хувьчилсан үзүүлэлт/
 - Шинээр гаргасан санал, санаачилга /Тоон үзүүлэлт/
 - Сургалт, хөтөлбөрт хамрагдсан байдал /Тоон үзүүлэлт/
 - Холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон байдал
- 2.1.9 Алтан-Од: Оны шилдэг ажилтан-5 хүртэлх хүн /харуул хамгаалалтын ажилтан, үйлчилгээний ажилтан, жолооч, тогооч**
 - Тухайн байгууллагын гишүүнчлэлийн хугацаа 2-оос дээш жил байх.
 - Тухайн байгууллагад 2-оос доошгүй жил ажилласан байх.
 - Тухайн жилд мэргэжлийн ёс зүйн алдаа дутагдалгүй ажилласан байх.
 - Татвар, нийгмийн даатгалын өргүй байх /байгууллага/

- Санхүүгийн зохицуулах хорооны Зохистой харьцааны шалгуурыг тухай жилдээ хангаж зөрчилгүй ажилласан байдал /байгууллага/
 - Хариуцсан ажлын гүйцэтгэл /Хувьчилсан үзүүлэлт/
 - Сургалт, хөтөлбөрт хамрагдсан байдал /Тоон үзүүлэлт/
- 2.1.10** Журмын 2.1.4-2.1.9 заалт дахь шагналуудыг “Алтан-Од” цом болон мөнгөн шагнал дагалдах бөгөөд мөнгөн шагнал нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү буюу түүнээс дээш байна. Мөнгөн шагналыг тухайн ажилтныг шагнуулахаар тодорхойлсон байгууллага нь өөрийн хөрөнгөөс гаргана.
- 2.1.11** Шилдэг ажилтны шагналд нэр дэвшигч нь өөрийн байгууллагын шагналаар шагнуулж байсан, мөн Холбооны шагналын шалгуурыг хангасан байна.

2.2. Шилдэг байгууллагуудын шагнал нь дараах төрөлтэй байна.

2.2.1. Оны онцлох хүн /байгууллага – 1 байгууллага

- Банк бус санхүүгийн салбарын нийгэм, эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, тухайн салбарыг хөгжүүлэхэд идэвх санаачлага гарган, шинэ төсөл хэрэгжүүлсэн, олон улсын үнэлгээ хийлгэсэн, инноваци технологийн шинэ шийдэл нэвтрүүлсэн, онцгой хувь нэмэр оруулсан хувь хүн, байгууллагыг “**Оны онцлох хүн /байгууллага**” өргөмжлөлөөр шагнаж урамшуулна.

2.2.2. Оны шилдэг байгууллага - 1 байгууллага

- Гишүүнчлэлийн хугацаа 3-аас дээш жил болсон байх
- Татвар, нийгмийн даатгалын өргүй байх-10 оноо
- Нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлсэн байдал /Хувьчилсан үзүүлэлт/-10 оноо
- Активын өсөлт /Хувьчилсан үзүүлэлт/-15 оноо
- Зээлийн багцын чанар /Хувьчилсан үзүүлэлт/-15 оноо
- СЗХ-ны зохистой харьцааны шалгуурыг тухайн жилдээ хангаж зөрчилгүй ажилласан эсэх-20 оноо
- Шинэ үйлчилгээ, техник технологийн дэвшлийг нэвтрүүлсэн байдал-10 оноо
- Холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож дэмжлэг үзүүлсэн байдал-20

2.2.3. Оны шилдэг санхүүгийн хүртээмжтэй байгууллага – 1 хүртэлх байгууллага

- Гишүүнчлэлийн хугацаа 2-оос дээш жил болсон байх
- Активын өсөлт /Хувьчилсан үзүүлэлт/-20 оноо
- Харилцагчийн тооны өсөлт /Хувьчилсан үзүүлэлт/-30 оноо
- Салбар нэгжийн тооны өсөлт /Тоон үзүүлэлт/-10 оноо
- Ажлын байрны тооны өсөлт /Тоон үзүүлэлт/-20 оноо
- Холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож дэмжлэг үзүүлсэн байдал-20 оноо

2.2.4. Оны шилдэг бүтээгдэхүүн үйлчилгээтэй байгууллага - 1 хүртэлх байгууллага

- Гишүүнчлэлийн хугацаа 2-оос дээш жил болсон байх
- Зах зээлд шинээр нэвтрүүлсэн бүтээгдэхүүний үйлчилгээний нэр төрөл, анхдагч байдал-30 оноо
- Харилцагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн байдал-20 оноо
- Өргөн хүрээг хамарсан байдал-10 оноо
- Шинэ техник технологи нэвтрүүлсэн байдал-20 оноо
- Холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож дэмжлэг үзүүлсэн байдал-20 оноо

2.2.5. Оны шилдэг нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч байгууллага - 1 хүртэлх байгууллага

- Гишүүнчлэлийн хугацаа 2-оос дээш жил болсон байх

- Тухайн жилд нийгмийн сайн сайхны төлөө шинэ санал санаачилга дэвшүүлж, идэв зүтгэл, хүчин чармайлт гарган, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсартайгаар хэрэгжүүлсэн байх. /Хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлуулсан зарын эх хувь, фото зураг, санхүүгийн баримт зэргээр хийгдсэн ажил үйлчилгээг баталгаажуулсан байх/ -30 оноо
- Хэрэгжүүлсэн ажил нь өргөн хүрээг хамарсан байх-30 оноо
- Татвар төлөлтийн байдал-10 оноо
- Холбооны үйл ажиллагаанд идэвх санаачлагатай ажилласан байх-30 оноо

2.2.6. Оны шилдэг Зээлээс бусад үйлчилгээ үзүүлэгч байгууллага – 1 байгууллага

- Гишүүнчлэлийн хугацаа 2-оос дээш жил болсон байх
- Татвар төлөлтийн байдал-10 оноо
- Гүйлгээний дүнгийн өсөлт /Хувьчилсан үзүүлэлт/ – 30 оноо
- Харилцагчийн өсөлт /Хувьчилсан үзүүлэлт/ – 40 оноо
- Холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон байдал – 20 оноо

Гурав. Шагналд тодорхойлох, материал хүлээн авах

3.1.Холбооны гишүүн байгууллага шагналд тодорхойлох байгууллага, ажилтны тухай дараах баримт бичгийг эх хувиар нь Ажлын албанд хүргүүлнэ.

3.1.1. Шилдэг байгууллагаар шагнуулахад дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

- Байгууллагын албан хүсэлт
- Гишүүн байгууллагын өөрийн тодорхойлолт, танилцуулга
/Тодорхойлолтод байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны голлох санхүүгийн үзүүлэлтүүд (санхүүгийн тайлан хавсаргах), үйл ажиллагаанд нэвтрүүлсэн хөрөнгө оруулалт, ажил үйлчилгээний тухай тоон баримтууд, шинээр бий болгосон ажлын байрны тоо, хүрсэн үр дүнг тусгасан байна/
- Татварын байгууллагын тодорхойлолт,
- СЗХ-ны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн 1 жилийн байдлаар хангасан тайлангийн хариу
- Маягт бөглөж ирүүлнэ.

3.1.2. Шилдэг ажилтнаар шагнуулахад дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

- Байгууллагын албан хүсэлт
- Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр */зөвхөн "Оны шилдэг Гүйцэтгэх захирал" шагналд хамааралтай/*
- Ажилтны ажил байдлын тодорхойлолт /Тухайн ажилтны сүүлийн 2-5 жилийн ажлын ололт амжилт, үр бүтээл, ажлын гол үзүүлэлт, хүрсэн үр дүнг тусгасан байх/
- Ажилтны анкет
- Хурлын тэмдэглэл
- Ажилтны нийгмийн даатгалын лавлагаа
- Маягт бөглөж ирүүлнэ.

3.2.Тухайн жилд шалгуурыг хангах материалууд ирээгүй тохиолдолд аль нэг шагналыг олгохгүй байж болно.

3.3.Шагналын тодорхойлолтод байгууллагын Гүйцэтгэх захирал гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан байна.

- 3.4. Үндэсний их баяр наадам, санхүү, эдийн засгийн ажилтны өдөр, тухайн салбарын болон байгууллагын түүхт ой /5, 10, 15, 20 ... /-н өдрийг тохиолдуулан шагнаана.
- 3.5. Шагналын материалыг тухайн арга хэмжээ, баяр ёслол болохоос 30 хоногийн өмнө ирүүлсэн байна.
- 3.6. Журмын 3.1 дүгээр зүйлд заасан баримт бичгийг бүрэн бүрдүүлсэн тохиолдолд материалыг хүлээн авна.
- 3.7. Энэ журмын 2.1, 2.2 дугаар зүйлд заасан шалгуур нөхцөл, Санхүүгийн зохицуулах хорооны шалгуур үзүүлэлтийг хангаагүй, мөн хууль хяналтын байгууллагад шалгагдаж байгаа, холбогдох баримт бичгийг хугацаанаас хожимдуулж ирүүлсэн тохиолдолд тухайн байгууллага, ажилтны шагналын материалыг хүлээн авахгүй.
- 3.8. Холбоо нь гишүүн байгууллага, түүний ажилтныг холбогдох төрийн болон салбарын төр захиргааны байгууллагуудын шагналд нэр дэвшүүлж болох бөгөөд шагналд нэр дэвшигчийг дэмжиж ажиллана.

Дөрөв. Холбооны шагналын зардлыг бүрдүүлэх

- 4.1. Холбооны шагналыг дагалдах Цом, Үнэмлэх, Тэмдэгний төлбөрийг шагнуулахаар тодорхойлсон тухайн байгууллага нь өөрийн хөрөнгөөс гаргана.
- 4.2. Холбооны шагналаар шагнуулсан байгууллага, ажилтан нь хууль тогтоомж, ёс зүйн болон холбогдох бусад дүрэм, журам зөрчсөн, улмаар Холбооны Ёс зүйн түр хороогоор шийдвэр гарсан тохиолдолд Холбоо өөрийн шагналаа эргүүлэн татах бөгөөд журмын 4.1-д заасан төлбөрийг буцаан олгохгүй.

-- o --